

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАНЫ
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛӨӨС 2013
ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2014.01.10

Өлгий

ХОТ

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл нь 2013 онд орон тооны бус дарга, нарийн бичгийн дарга болон салбар зөвлөлийн 9 гишүүнтэйгээр /нийт бүрэлдэхүүн 11/ салбар зөвлөлийн ажлыг жил, улирал сар бүр төлөвлөн ажиллалаа.

Салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн дүрэм, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам болон бусад заавар журам зөвлөмж, ТАЗ-өөс тухай бүр өгсөн чиглэл үүрэг даалгавруудыг биелүүлэхэд гол анхаарлаа чиглүүлж, жилийн эхэнд ТАЗ-ийн салбар зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар салбар зөвлөлийн 2013 оны үндсэн зорилтуудыг дэвшүүлж, хурадлааны дэг болон жилийн ажлын төлөвлөгөөг баталж, ажлын биелэлтийг улирал тутам дүгнэж ажиллаа. Төрийн албан хаагчдын эрхэмлэх 9 зүйлийг хэрэгжүүлэх, Төрийн албаны тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах үүднээс 2013 оныг “Төрийн албан хаагчдын ажлын үр дүн, хариуцлага, хэрэгжилт”-ийг хангах уриалга гаргасантай холбогдуулан тайлант оны үндсэн зорилтыг эдгээр ажлыг хэрэгжүүлэхэд чиглүүллээ.

Салбар зөвлөл нь тайлангийн хугацаанд салбар зөвлөлийн гишүүдийн хурлыг 12 удаа хийж, 36 тогтоол, 4 зөвлөмж, 3 албан даалгавар, 108 албан тоот боловсруулан, нийт 32 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шалгаж дүгнэлтийг ТАЗ-ийн салбар зөвлөлийн гишүүдийн хуралдаанаар хэлэлцэн, маргаан хянан шалгах комиссыг тухай бүр байгуулж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж биелэлтэнд хяналт тавьж ажиллаа.

Нэг. Стратегийн төлөвлөлт болон гүйцэтгэлийн
удирдлагын талаар

Салбар зөвлөл нь ТАЗ-ийн зохион байгуулалтын бүтцийн салбар нэгж мөн учир Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах , Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах , ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,ТАЗ-ийн дүрэмд заасан Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаа. Төсвийн тухай хуулийн хүрээнд нийт төрийн байгууллагуудын санхүүтэй холбоотой үйл ажиллагааг ил тод байлгах үүднээс шилэн дансанд шилжих эхлэл тавигдаж, цахим хуудасанд болон мэдээллийн самбарт тухай бүр гаргасан шийдвэрийг ил тод нээлттэй байрлуулах ажил хэвшил боллоо. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс аймгийн ЗДТГазарт жендэрийн тэгш байдал хариуцсан мэрэгжилтэнтэй болгож, хуулийн хэрэгжилтийг хангах, судалгаа гаргуулж, мэдээллийн сан бий болгоод байна. Одоогоор нийт албан хаагчдын 43 % нь эмэгтэйчүүд эзлээд байгаа судалгаатай байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах , ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний биелэлтийг сар, улирал, жилээр дүгнэж, Авлигатай тэмцэх газарт төлөвлөгөөний биелэлт болон Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын дагуу тайлангаа гаргаж хүрүүлсэн. Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг дүгнэхээр АТГазраас шинжээчдийн баг гарч ажилласан ба манай аймаг 21 аймгаас 7 дугаар байранд орсон байна. Энэ бол Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах , ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжилт сайн байгаа гэж дүгнэж байна.

Салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, ТАЗ-ийн дүрэм, холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, ТАЗ-ийн салбар зөвлөлийн ажиллах журам, Төрийн албаны зөвлөлөөс баталсан бусад заавар журам, удирдамж, зөвлөмжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаа.

Салбар зөвлөл нь тайлангийн хугацаанд дээрх хууль, тогтоомжуудын биелэлтийг зохион байгуулах, нутгийн төр, захиргааны байгууллагуудын төрийн албыг мэргэшсэн мэдлэг чадвартай албан хаагчдаар бэхжүүлэх, тэдний тогтвортой үр: ашигтай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд байнга анхаарч холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтэнд байнга хяналт тавьж, чиг үүргийн дагуу аймгийн нутгийн захиргааны байгууллагад сумдын ЗДТГ-ыг удирдлага, төрийн албыг чанаржуулах, мэргэшсэн боловсон хүчнээр хангах, удирдлагын үндэсний чадавхийг дээшлүүлэх, энэ талаар төрийн албаны төв байгууллагын баримтлах бодлого, чиглэл, заавар журам, зөвлөмжийг тэдэнд сурталчлах, танилцуулах, хэрэгжүүлэхэд арга зүйн зөвлөлгөө өгөх, эдгээрийн биелэлтэнд хяналт тавьж ажиллав.

Тайлангийн хугацаанд салбар зөвлөлөөс дэвшүүлсэн нэг гол зорилт бол төрийн албанд ил тод, шударга ёсны зарчмыг хүний нөөцийн бодлогод чиглүүлж аливаа илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж байв.

2013 оны 2 дугаар сарын эхэнд бүх сумдын Засаг дарга, ТГ-ын дарга нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинар зохион байгуулагдав. Үүнд: 2012 оны ажлын гүйцэтгэлийн талаар болон 2013 онд хийж гүйцэтгэх ажлын талаар хэлэлцэж, цаашдын үйл ажиллагааны чиглэл өгөгдлөө.

Аймгийн ЗДТГ-ын үүдэнд иргэдийн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авах цэг байгуулан 2 орон тооны ажилтан тогтмол ажиллуулж байна. Иргэдийн Өргөдөл, гомлыг хүлээн авч шийдвэрлэх ажлын хэсэг үйл ажиллагаагаа эрчимтэй явуулж байна. 70424042 дугаартай нээлтэй утас тогтмол ажиллуулж байгаа. Уг ажлын хэсгийн ажлын журмыг <http://bayan-olgii.gov.mn>-д болон ЗДТГ-ын мэдээллийн самбарт байршуулсан ба аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга нарын ард иргэдтэй уулзах өдөр, цагийг мэдээллийн самбарт байршуулсан. Уулзах хүмүүст дугаар өгч очир дарааллын дагуу зохион байгуулж ажиллаж байна. Иргэний нийгмийн байгууллагууд төрийн үйл ажиллагаанд хяналт байнга тавьж ажиллаж байна. Иргэдийн санал, хүсэлт, гомдлыг 134242 дугаараар мессэжээр хүлээн авч, 70424042 дугаартай санал авах нээлттэй утас тогтмол ажиллаж байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2012 оны бүрдүүлэлтийн талаар Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, ажилтнууд Ховд Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн хурлын зааланд төрийн албан хаагчдад сургалт явуулсан. Уг сургалтанд 150 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан.

Салбар зөвлөлийн 2013 оны 05 дугаар тогтоолоор нутгийн захиргааны байгууллагуудад шалган зааварлах ажлын удаирдамж гарган баталж, сумдад болон зарим нутгийн захиргааны байгууллага, хэлтэст хийсэн шалгалтын талаар зааварчлах явцад илэрсэн төрийн албаны мэргэшлийн шалгалт өгөөгүй байсан ба ажлын байрны тодорхойлолтонд заагдсан шаардлага хангаагүй, туслах түшмэлийн ангилалд шалгалт өгсөн иргэнийг шууд дэс түшмэлээр томилсон, хууль зөрчсөн тухайн байгууллага бүрт албан шаардлага явуулж үүрэгт ажлаас чөлөөлүүлсэн юм. Уг шалгалтаар гарсан зөрчлийг арилгуулж, Ногооннуур сумын ЗДТГазар, Буянт сумын ЗДТГ, Бугат сумын ЗДТГазар, Алтанцөгц сумын ЗДТГазар, Баяннуур сумын ЗДТГазарт ажиллаж байгаа хууль бус томилогдсон 12 хүний ажлын байранд 2013 оны 9 дүгээр сард сонгон шалгаруулалт зохион байгуулсан юм. Шалган зааварчлах ажлын мөрөөр авах арга хэмжээний тухай тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, төрийн албанд ил тод шударга ёсыг эрхэмлэх, зөрчил дутагдал гаргахгүй байх, Төрийн албаны тухай хууль, төрийн албаны стандартыг ажилд мөрдлөг болгох талаар бүх нутгийн захиргааны байгууллагууд, сумдын удирдлагад албан даалгавар хүргүүлж биелэлтэнд хяналт тавьж ажиллаж ирлээ. Шалган зааварлах ажлын мөрөөр авсан арга хэмжээ дээрх дутагдлуудыг хэрхэн засч залруулсан талаарх авсан арга хэмжээ үндсэн баримт бичиг, дэлгэрэнгүй илтгэх хуудсыг тухай бүр ТАЗ-д хүргүүлж, арга зүйн зөвлөгөө авч байлаа.

2013 онд Төрийн жинхэнэ албаны боловсон хүчний хэрэгцээ хангалтыг шалган зааварчлах ажлыг сумдад хийхээр төлөвлөж, одоогоор Ногоонуур, Сагсай, Алтанцөгц, Бугат, Өлгий, Баяннуур зэрэг 6 сумдад зохион байгуулж явуулсан дүнг

салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, илэрсэн дутагдлыг арилгах зөвлөмж болон зарим сумдад шаардлага хүргүүлж хугацаат үүрэг даалгавар өгсөн болно.

Шалган зааварлах ажил хийсэн сумдад илэрсэн нийтлэг дутагдал бол байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөө, Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр нь байгууллагын стратегийн төлөвлөгөөтэй уялдаагүй ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт дутуу, ерөнхий менежерийн ажилтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээ, түүний дүгнэх журам зааврыг баримтлаагүй, мөн төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ хангалтгүй зэрэг нийтлэг дутагдлууд илэрсэнд дүгнэлт хийж, дэлгэрэнгүй арга зүйн зөвлөмж болон холбогдох журам заавруудыг хүргэж, уг зөвлөмж, заавар журмыг баримтлан ажиллах талаар чиглэл өглөө.

Бүх нутгийн захиргааны байгууллагуудад болон сумдад ёс зүйн хороог байгуулагдан үйл ажиллагаагаа нь жигдэрсэн болно. Тэдний өдөр тутмын ажилд заавар зөвлөгөө өгч ажилласан ба 2013 онд Төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой 4 асуудлыг Салбар зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хороогоор авч хэлэлцэж, Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд зохих шийдвэрийг гаргасан болно.

Төрийн албаны тухай хууль тогтоомж төрийн албаны стандарт түүнийг хэрэгжүүлэхэд салбар зөвлөлийн чиг үүрэгт хамрах төлөвлөгөөнд тусгагдсан гол арга хэмжээний нэг болох төрийн албан хаагчдын бүртгэл хөдөлгөөнийг төгөлдөржүүлэхэд онцгой анхаарч тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гаргахдаа тухайн жилд гарсан хүний нөөцийн мэдээллийн талаарх өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн программын /ХНУМСП/ зохих хэсэгт үнэн зөв бүрэн тусгахад онцгой анхаарч ажиллаа.

Одоо аймгийн хэмжээнд 2013 оны 01 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар төрийн албан хаагчдын мэдээлэл, өөрчлөлт хөдөлгөөн, цалин, хүний нөөцийн мэдээллийн санд орсон ба ХНУМСП-аас бэлдэж хүргүүлээд байна.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн чиг үүрэгт хамрагдах төрийн албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдэл олгох бууруулах, төрийн захиргааны албан тушаалтнуудын ангилал зэрэглэлийг зөв тогтоож, мөрдөж байгаа зсэхэд болон

төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадвар олгох, журам заавруудын биелэлтэнд хяналт тавьж энэ талаар холбогдох байгууллагад арга зүйн зөвлөгөө туслалцаа өгч ажиллаа.

Тайлант хугацаанд салбар зөвлөлд цалин хөлсний нэмэгдэл, ангилал зэрэглэл, ур чадварын нэмэгдлийн талаар ирсэн 2 иргэний өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсний зэрэгцээ сумдад болон Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг болох төрийн захиргааны байгууллагуудад ажиллаж байгаа 400 гаруй төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг харгалзан зэрэг дэв олголтыг хянаж, 2013 онд 22 албан хаагчид шинээр зэрэг дэв, 16 албан хаагчдын зэрэг дэвийг ахиулах асуудлыг жилийн эхэнд салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, улмаар Засаг даргад өргөн барьж батлууллаа.

Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолоор баталсан Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ ангилал зэрэглэлийг тайлант онд шалган зааварлах ажлыг хийсэн 6 сумдаас шалгаж үзэхэд Бугат, Ногоонуур, Алтанцөгц, Сагсай, Баяннуур зэрэг сумдад цалингийн ангилалыг буруу тогтоосон зөрчил илэрлээ. Тухайлбал сумдын ЗДТГ-ын дарга нар томилох төрийн сангийн төлөөлөгчдийг ТЗ-5-аар цалинжуулж Засгийн газрын тогтоолыг зөрчсөнийг илрүүлэн холбогдох эрх зүйн актыг нэг мөр дагаж мөрдөх талаар арга зүйн зөвлөмж өгч албан шаардлага хүргүүллээ.

Төрийн захиргааны жинхэнэ албан тушаалд анх орж туршилтын хугацааг амжилттай давсан цаашид төрийн захиргааны байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж чадахаа харуулсан 38 төрийн захиргааны жинхэнэ албан тушаалтанд төрийн албаны тухай хууль, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 199 дүгээр зарлигаар батлагдсан журмын дагуу тангараг өргүүлэх асуудлыг 2014 оны 01 дугаар сарын 08-ны өдөр ёслол төгөлдөр зохион байгууллаа.

Салбар зөвлөл нь тайлант хугацаанд төрийн албан хаагчдын ур чадвар, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх хариуцлага сахилгыг сайжруулах ажлыг бодитой үнэлэхэд тэдэнтэй байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлтийг оны эхний сарын 20-ны дотор бүх байгууллагуудаар гаргуулж товчоог нэгтгэн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгч энэ талаар аймгийн удирдлагад танилцуулж цаашид үйл ажиллагаанд чиглэл өгч ажиллав.

2013 онд аймгийн ЗДТГ-ын төрийн захиргааны 36 албан хаагчийн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн батлах ажлын хэсэг гаргаж нэг бүрчлэн байгууллагын хэтийн стратегийн төлөвлөгөөтэй уялдуулан дахин боловсрууллаа.

Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын 2013 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг ажилтан бүрээр дүгнэж эцсийн үр дүнгээр тушаал гаргаж, гэрээнд хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн 8 албан хаагчдыг сарын цалингийн 40-60 хувь хүртэл хувиар шагнаж урамшуулсан ба 2013 оны ажлыг дүгнэхэд, төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй ерөнхий менежер, менежер /нэгжийн дарга/-тай байгуулсан гэрээнүүдийг нэг бүрчлэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, 2014 оныг ерөнхий менежер, менежерүүдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллах зорилт тавин ажиллаж байна.

Хоёр. Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийн талаар

Тайлант хугацаанд тус аймагт нийт 5295 төрийн албан хаагч ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь нийт албан хаагчдын ур чадвар, мэдлэг, мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх ажлын үүрэг хариуцлагыг сайжруулах, улмаар ард иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай ил тод, чирэгдэлгүй хүргэхэд тавих хяналтын нэг хэлбэр бол төсвийн ерөнхий захирагч, ерөнхий менежертэй, ерөнхий менежерүүдийн менежертэй, мөн төрийн жинхэнэ албан хаагчидтай байгуулах үр дүнгийн гэрээ, түүний биелэлтийг үнэн зөв бодит байдлаар дүгнэхэд арга зүйн туслалцаа үзүүлэх явдал билээ.

Салбар зөвлөл нь орон нутагт боловсон хүчний хэрэгцээний төлөвлөлт, нөхөн хангалт, хүний нөөцийн төлөвлөлт төрийн албан хаагчдын сургалт, төрийн албаны мэргэшлийн шалгалтг нөөц бүрдүүлэлт түүгээр үйлчлэх төрийн захиргааны жинхэнэ удирдах албан тушаалтан болон ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх (дарга эрхлэгч) нарын сонгон шалгаруулалт зэрэг төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг зохицуулан стандартын хэрэгжилтийг хангах, шалган зааварлах ажлуудыг гардан зохион байгуулж, энэ талаарх холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудыг нэг мөр дагаж мөрдөхтэй холбогдсон мэргэжил, арга

зүйн удирдлагаар хангаж, дээрх багц асуудлуудын хүрээнд Засаг даргын бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд үндсэн ажлаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

. Манай аймгийн хувьд гадаад дотоодын их, дээд сургууль төгссөн одоо ажил идэвхтэй хайж байгаа 700 орчим иргэн байгаа ба зарлагдсан ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан нөхцөлд иргэдийг аль болох төрийн албаны мэргэшлийн шалгалтанд хамруулах, тэдний дотроос мэргэжил боловсролоор шинэ залуу боловсон хүчнүүдийн халааг бэлтгэхэд анхаарч ажиллаж байгаа.

Сүүлийн жилүүдэд орон нутагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтыг ил тод шударга явуулж байгаа, онлайнаар бүртгэж, цахим хэлбэрээр явуулж эхэлсэн нь нь төрийн албаны мэргэшлийн шалгалтыг ямар нэг маргаан, дуулиан гаргахгүй байх бүх нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэж байна. Энэ нь төрийн албаны төв байгууллага болон орон нутгийн салбар зөвлөлийн нэр хүндийг өсгөх үндсэн алхам гэж үзэж олон нийтэд өргөнөөр сурталчилан ажиллаж байна. 2013 онд салбар зөвлөлд нийт давхардсан тоогоор 32 иргэний болон Төрийн албаны зөвлөлөөс шилжүүлсэн 5 иргэний маргааныг хүлээн авч салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж тус бүрт салбар зөвлөлийн тогтоолоор маргаан хянан шалгах комисс байгуулан ажиллууллаа. Эдгээр өргөдөл гомдлыг ангилан үзэхэд ажпаас хууль бус халагдсан 4, төрийн албаны мэргэшлийн шалгалтанд орж нөөцөнд бүртгэгдсэн боловч ажилд томилоогүй 3, цалингийн ангилал зэрэглэлтэй холбоотой 3, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэх 2, сонгон шалгаруулалттай холбоотой 6, бусад асуудлаар 18 өргөдөл ирүүлсэн байгааг дээрх журмын дагуу шалгаж, дүгнэлтийг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж хугацаанд хариуг өглөө.

Тайлант онд аймгийн хэмжээнд богино хугацааны /1-3 хоног/ сургалтыг нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран 18 удаа зохион байгуулахад нийт 860 гаруй төр захиргаа, уйлчилгээний удирдах болон гүйцэтгэх ажилтнуудыг хамруулсан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гарсан төлөвлөгөөний дутуу Удирдлагын академийн 7-14 хоногийн сургалтанд сумдын ЗДТГ-ын дарга,

байгууллагын дарга, мэргэжилтэн, ЗДТГ-ын хэлтэс, тасгийн дарга, мэргэжилтэн зэрэг 120 орчим төрийн албан хаагчдыг хамруулав.

Удирдлагын академийн 2013-2014 оны хичээлийн жилд нутгийн захиргааны байгууллагуудаас нийт 2 хүнийг сонгон шалгаруулж явуулсан ба тэд одоо тус академид суралцаж байна.

Байгууллагууд төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, баримтлах үүднээс хуурууны хээгээр бүртгэдэг төхөөрөмжийг байгууллагуудад байрлуулсан болно. Ингэснээр цаг ашиглалтыг цахим хэлбэрт оруулж, хуурамчаар бүртгэдэг асуудлыг бүр мөсөн таслан зогсоолоо. Төрийн албан хаагчдын цаг ашиглалтанд хяналт тавих механизм бүрдээд байна.

Орон нутаг дахь хуулийн байгууллагуудын удирдлагуудын уулзалт тогтмол явагдаж байгаа. Хууль сахиулах байгууллагуудын хамтарсан сургалт, сурталчилгааг тогтмол явуулж байгаа ба иргэдэд хууль тогтоомжийн гарын авлага бэлтгэж тарааж байгаа, Засаг даргын Тамгын газарт хууль тогтоомжийн булан ажлуулж эхлэв. Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлагыг нийтийн албанд ажиллаж байгаа нийтийн албан хаагчдын 1/3 –д тараасан болно. Мөн байгууллагуудад Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхтгэлийг тарааж өгөв. Мөн Хууль зүйн туслалцаа үзүүлэх төвөөр иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг тогтмол хийж байна.

Иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор “Аманат”, “Монгол Заман” сонин, Олон нийтийн радио, телевизийн салбар, “Дербес”, “Наз” телевизтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, вэб хуудсуудыг ашиглаж байгаа.

Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал ба мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэд олон нийтэд хяналт тавих боломжийг олгох талаар тухайн байгууллагаас зохион байгуулж буй ажилтай танилцан заавар зөвлөмжийг өгч ажиллалаа.

Гурав. Удирдах ажилтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх болон мэдээллийн технологийг хэрэгжүүлэх талаар

Сум, байгууллага, агентлагуудын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангаж, төрийн захиргааны стандартыг хангуулах талаар мэргэжлийн зөвлөгөө өгч, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллав. МУ-ын хууль тогтоомж, Засгийн газар, аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээг цаг тухайд нь хийж гүйцэтгэв. Аймаг, сум, багуудын уялдаа холбоог сайжруулахын тулд бүх багийн Засаг дарга, БИНХ-ын дарга нарын сургалт, семинарыг 2 удаа зохион байгуулав. Давхардсан тоогоор нийт 400 гаруй төрийн албан хаагчид орон нутгийн сургалтанд хамрагдав.

Сум, байгууллагын удирдах ажилтнуудыг гадаад, дотоодын сургалтанд явуулах, хөгжиж буй орнууд болон хөгжсөн орнуудын туршлага судлаж, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд онцлон анхаарч байна. 2013 онд аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, зарим сумдын Засаг дарга нар Солонгос улс, ОХУ-ын Алтай хот, Казакстан улсын Асатан хот зэрэг орнуудаар ажил төрлийн чиглэлээр явж, туршлага судалсны дээр аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын болон нутгийн захиргааны байгууллагын 15 ажилтныг хил залгаа БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймагт 7 хоног аялуулж амруулахын зэрэгцээ тухайн аймгийн төр, захиргааны ажилд танилцуулсан болно.

Эдгээр ажлын үр дүнд ерөнхий менежер, менежер, гүйцэтгэх ажилтнуудын манлайлах ур чадвар дээшилж, өөрсдийн ажилд санаачлагатай хандаж төрийн үйлчилгээний чанар хүртээмж, сайжирч ахиц дэвшил гарсан.

Манай аймгийн хувьд хамгийн их тулгамдсан асуудал бол ажилгүйдлийг багасгах, их дээд сургууль төгсөж ирсэн мэргэжилтэй боловсон хүчнүүдийг ажлаар хангах явцад тодорхой бодлого барьж ажилласны үр дүнд 2013 онд 1200 гаруй иргэн байнгын болон түр ажлын байртай болж, 200 иргэнийг байнгын ажлын байраар хангаад байна.

Энэ нь ажилгүйдлийг багасгах, түгээмэл мэргэжилтэй олон залуу боловсон хүчнүүдийг нарийн мэргэжилтэй болгон, улмаар ажпаар хангах бүрэн боломжтой болсон.

Аймгийн хэмжээнд төрийн албаны стратеги төлөвлөлт, боловсон хүчний хэрэгцээ хангалтыг шалган зааварчилж, удирдамжаар хангаж, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжлийн зөвлөгөө арга зүйн туслалцааг байнга үзүүлэв.

Төрийн албаны тухай хууль тогтоомж болон Төрийн албаны зөвлөлөөс тухайн жилд гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж ажиллав. Тухайн онд Төрийн албаны зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэл удирдамж, гаргасан шийдвэрийн биелэлтийг тухай бүр гаргаж явуулж байсан ба мэдээ тайлан хожимдуулах, тасалдуулах явдал гараагүй. Төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулан стандартын хэрэгжилтийг 6 сум, 3 нутгийн захиргааны байгууллагуудад шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах хугацаатай үүрэг өгч биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулж, бүх сум, байгууллагуудад хувийн хэрэгт байвал зохих материал түүнийг бүрдүүлэх, сум, байгууллага бүр төрийн албан хаагчидтай мэдээллийн санг тогтмол ажиллуулж сурах талаар зөвлөмж хүргүүлсний дээр аймгийн ЗДТГ-ын ажилтнуудын хувийн хэргийг шинэчлэн хийж, аймгийн төвийн байгууллагуудын хүний нөөцийн ажилтнуудад танилцуулж, үүнийг улам баяжуулж хэрэгжүүлэх талаар арга зүйн зөвлөмж өглөө.

Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ оалбан тушаалд анх орох иргэдээс төрийн албаны мэргэшлийн шалгалтыг тайлант онд 1 удаа, Төрийн албаны удирдах албан тушаалтанд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг тайлант онд 3 удаа зохион байгуулсан. Нэр дэвшүүлж томилох эрх бүхий этгээдэд уламжласны зэрэгцээ нэр дэвшүүлсэн иргэд нь тухайн албан тушаалтанд томилогдон ажиллаж энэ талаар маргаан гараагүй болно.

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон төрийн жинхэнэ албаны удирдах ажилтанд томилогдох ажилтанг нөөцөд бүртгэх нөөцийн сан бүрдүүлэх, нөөцийн сангийн мэдээллээр үйлчлэх ажлыг холбогдох хууль журмын

дагуу гүйцэтгэж, мэдээг тухай бүр хүргүүлж байв. Жилийн эцсийн нөөцийн судалгааны тайланг жилийн ажлын тайлантай хамт хүргүүллээ.

Дөрөв. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны ур дагаврын шалгуур үзүүлэлтийн талаар

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь тайлангийн хугацаанд Төрийн албаны тухай хууль, тогтоомж, стандарт, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт төрийн жинхэнэ албан хаагчдын ёс зүйн дүрэм, түүнийг хэрэгжүүлэх аргачлал журам, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан зөвлөмж, Төрийн албан хаагчдын эрхэмлэх есөн зүйлийг хэрэгжүүлэхэд үндсэн ажлаа чиглүүлэн, салбар зөвлөлийн ажлыг сар, улирал, жилээр төлөвлөн, гишүүдийн хурлыг сард 1-ээс доошгүй удаа хийж, тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж, хамтын удирдлагын зарчмаар ажиллаж, чиг үүргийн дагуу дараах үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаа. Үүнд:

1. Аймгийн хэмжээнд төрийн албаны стратеги төлөвлөлт, боловсон хүчний хэрэгцээ хангалтыг шалган зааварчилж, удирдамжаар хангаж, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжлийн зөвлөгөө арга зүйн туслалцааг байнга үзүүлэв.

Төрийн албаны тухай хууль тогтоомж болон Төрийн албаны зөвлөлөөс тухайн жилд гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж ажиллав. Тухайн онд Төрийн албаны зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэл удирдамж, гаргасан шийдвэрийн биелэлтийг тухай бүр гаргаж явуулж байсан ба мэдээ тайлан хожимдуулах, тасалдуулах явдал гараагүй.

Төрийн албанд шинээр ажилтан сонгон шалгаруулах ажлыг ил тод, нээлттэй байлгах үүднээс тус аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс орон нутгийн захиргааны байгууллагуудад сул орон тооны захиалга гарсан үед нэн даруй ирүүлж байх шаардлага тавьж ажиллаж байна. Одоогийн байдлаар сул орон тооны захиалгыг Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Боловсролын газар, Буянт, Бугат, Ногооннуур сумдын ЗДТГазруудаас ирүүлээд байна.

Аймгийн ЗДТГ-ын төрийн албан хаагчдын хувийн хэргийн баяжилт хийж, шилжилт хөдөлгөөнийг тогтмол хөтлөн ажиллаж байгаа. Төрийн албан хаагчдын томилсон, чөлөөлсөн тухай бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, мэдээллийн санг тогмтол ажиллуулж байна. Төрийн бүх шатны албан хаагчдын ажил, үүргийг тодорхой болгох үүднээс төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн гаргаж батлуулах ажиллагаа явагдаж байна. Төрийн албаны стандартын шаардлагыг хангасан ажлын байрны тодорхойлолт гаргахаар төлөвлөж байна. Ажлын хариуцлага алдсан, хууль тогтоомж зөрчсөн албан хаагчдад хариуцлага тооцох механизмыг бий болгож сайн ажилласныг нь ногоон картаар шагнах хариуцлага алдсан албан хаагчид улаан карт бичих зэрэг механизмийг бий болгосон. Уг хариуцлагын талоны тухай байгууллагын даргын шийдвэрээр журам гаргаж, мөрдлөг болгон ажиллаж байна. ЗДТГ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн гаргаж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн батлуулж үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

Төрийн жинхэнэ албаны болон үйлчилгээний байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын 8 сул орон тоог 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр, мөн 2013 оны 12 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд 8 төрийн захиргааны удирдах албан тушаалтны ажлын байр болон 2 төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны ажлын байранд, түүнчлэн Нутгийн захиргааны байгууллагуудын ажлын байрны 37 ажлын байрны сул орон тооны сонгон шалгаруулалтыг 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. Нийт 867 хүн сонгон шалгаруултанд хамрагдав. Үүнээс 89 хүн тэнцэж, 40 хүн ажлын байранд нэр дэвшигдээд байна. Одоогийн байдлаар нийт 66 хүн төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцөнд бүртгэлтэй байна. Сул орон тооны зарыг Орон нутгийн радиогоор 14 удаа явуулсан. Мөн Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn ЗДТГ-ын www.bayan-ulgii.mn сайтууд, www.facebook.com/bayanulgiiprovince гурппэд байршуулан нийтэд зарласан болно. Хүний нөөцийн ил тод байдлын талаар ЗДТГ-ын бэв сайтанд тухай бүр байршуулсан.

Төрийн жинхэнэ албанд ажиллаж буй албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ цаасан болон цахим

хэлбэрээр хуулийн хугацаанд авч, тайланг Авилгатай тэмцэх газарт хүргүүлэв. Нийт 434 албан хаагч ХАСХОМэдүүлгээ гаргаж өгсөн болно. Аймгийн Засаг даргын 2013 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 302 тоот Захирамжаар Аймгийн Төрийн албан хаагчдын Ёс зүйн дүрэм болон Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, бүх сумдад болон байгууллагуудад хүргүүлэн мөрдлөг болгон ажиллаж байна. Авлигын эсрэг 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллав. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр АТГазраас 2 удаа ажлын хэсэг ирж урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлаар тодорхой ажлууд зохион байгууллаа. Үйл ажиллагааны тайлан, мэдээг АТГазарт цаг тухайд нь хүргүүлэн ажиллав.

Аймгийн Засаг даргын 2013 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 302 тоот Захирамжаар Аймгийн Төрийн албан хаагчдын Ёс зүйн дүрэм баталж, бүх сумдад болон байгууллагуудад хүргүүлэн мөрдлөг болгон ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хороо аймгийн ЗДТГазарт үйл ажиллагаагаа явуулж байна. Бусад байгууллага, агентлагуудад Ёс зүйн хороог байгуулуулж тогтмол ажиллуулж байна. Төрийн албан хаагчдын эрхэмлэх 9 зүйлийг бүх албан байгууллага, албан хаагчдын албан тасалгааны өрөөнд байршуулсан болно. Төрийн албан хаагчдын ёс зүйн талаар орон нутгийн радиогоор ойлголт өгсөн. Иргэдийн гомдол, санал, зөрчлийн талаарх бүх төрлийн мэдээ, мэдээллийг 70424042 утсаар болон цахим хэлбэрийн <http://bayan-olgi.gov.mn> хаягаар тус тус авч байгаа болно. Ирсэн мэдээ, мэдээллийг ЗДТГазар цаг алдалгүй түргэн шуурхай хариуг нь өгч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлүүлэн ажиллаж байна. Санал авах хайрцаг ажиллуулж байна. Зөрчлийн талаарх мэдээлэл ирээгүй байгаа тул одоогоор бүртгэл хөтлөгдөөгүй.

2013-2014 оны хичээлийн шинэ жил эхлэхэд бүх сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт зориулан БСГазраас зохион байгуулсан. ЗДТГ-аас Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалтыг нийт төрийн байгууллагын бичиг хэргийн ажилтан болон дотоод асуудал хариуцсан ажилтнуудад сургалт зохион байгуулагдлаа. Бүх сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, хуулийн мэргэжилтнүүдэд болон БИНХ-ын дарга нарт зориулсан төрийн албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулагдсан. нийт давхардсан тоогоор 860 хүн

сургадтанд хамрагдсан. 2013 оны 4 сард аймгийн ЗДТГ-ын хуульзүйн хэлтэстэй хамтран Захиргааны ерөнхий хуулийн хэлэлцүүлгийн албан хаагчид, иргэдийн дунд 2 удаа хэлэлцүүлэн саналыг авч явуулсан. Хэлэлцүүлэгт нийт 82 төрийн албан хаагч, иргэд оролцсон. Жил бүр Засгийн газрын тэтгэлэгээр 2 төрийн жинхэнэ албан хаагчийг Удирдлагын академид сургаж байгаа.

Төрийн албаны зөвлөлөөс болон Авлигатай тэмцэх газраас, мөн дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажиллагаа явуулж хэрэгжилтийг цаг тухайд нь хүргүүлсэн болно. Авлигатай тэмцэх газраас Ногооннуур сумын Засаг дарга А.Мейрамхан болон Бугат сумын Засаг дарга Х.Ержанаттай холбоотой ирсэн зөрчлийг арилгуулах тухай зөвлөмжийн дагуу дээрх сумдын Засаг дарга нарт 2013 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 7-03/1684 тоот албан тоот, 6 дугаар сарын 24-ний өдрийн 1-01/1616 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн байна. Төрийн албаны стандартын талаарх сургалтыг бүх сумдын ЗДТГ-ын дарга, байгууллагын дарга нарт сургалт явуулсан. Төрийн албаны стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчтай холбоотой ямар нэгэн зөрчил, дутагдал гараагүй болно.

Төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй чирэгдэлгүй хүргэх, ил тод нээлттэй байдлыг бий болгох, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах чиглэлээр аймгийн цахим хуудсыг шинэчлэн ажлуулж байгаа бөгөөд төсөвт байгууллагуудыг цахим хуудастай болгох аян явагдаж байна. Одоогийн байдлаар аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, Улсын бүртгэлийн хэлтэс болон Хөдөлмөрийн хэлтсүүд өөрсдийн цахим хуудастай болсон ба зарим хэлтсүүд яамны вэб сайтанд өөрсдийн цахим хуудсаа байршуулсан байна.

Төрийн үйлчилгээний хүнд сурталыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 302 тоот захирамжаар Авлигын эсрэг үйл ажиллагааг аймгийн төрийн захиргааны байгууллагуудад хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2013 оны төлөвлөгөөг”-г баталсан билээ. Энэ төлөвлөгөөний хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлж, ухуулан сурталчлах, байгууллагын үйл ажиллагааг ил тод болгох,

удирдлагуудаас гаргаж буй шийдвэрийг ил тод, нээлттэй байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд сум, хэлтэс, агентлаг, төсөвт байгууллагуудын Авлига, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдлын талаарх тайланг авч хянан, дүн шинжилгээ хийв.

Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор төсөвт байгууллагуудыг сурталчлах, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн Засаг дарга нарын чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгууллаа. Мөн аймгийн 2013 оны төсөв, түүнтэй холбоотой мэдээллийг мэдээллийн самбар болон цахим хуудасанд байршуулав.

Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны бүх үе шатыг ил тод байлгах үүднээс аймгийн ЗДТГ-ын цахим хуудсаар дамжуулан тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн зар, үр дүнг нээлттэй мэдээлж байгаа бөгөөд Орон нутгийн радиогоор иргэдэд тогтмол зарлаж байгаа.

Төрийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын мэдээллийн самбарт үйлчилгээний төлбөр хураамжийн эрх зүйн үндэслэл жагсаалтын талаарх мэдээллийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр аймгийн цахим хуудасны Төрийн үйлчилгээ буланд болон хэлтэс, агентлагуудын мэдээллийн самбарт байршуулсан байгаа.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулан стандартын хэрэгжилтийг 6 сум, 3 нутгийн захиргааны байгууллагуудад шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах хугацаатай үүрэг өгч биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Ногооннуур, Бугат, Сагсай, Өлгий, Алтанцөгц, Баяннуур сумдад болон Эрүүл мэндийн газар, Музей, Монгол Алтайн нурууны Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаанд төрийн албаны шинэтгэлийн бодлого, стандарт, хүний нөөцийн бодлогын явц, үр дүнд хяналт шинжилгээ (мониторинг) хийж, дүнг салбар зөвлөлийн болон Засаг даргын зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцэж зөвлөмж боловсруулан хүргүүлээ.

Төрийн албан хаагчдын хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулж, бүх сум, байгууллагуудад хувийн хэрэгт байвал зохих материал түүнийг бүрдүүлэх, сум, байгууллага бүр төрийн албан хаагчидтай мэдээллийн санг тогтмол ажиллуулж сурах талаар зөвлөмж хүргүүлсний үндсэн дээр аймгийн ЗДТГ-ын ажилтнуудын хувийн хэргийг шинэчлэн хийж, аймгийн төвийн байгууллагуудын хүний нөөцийн ажилтнуудад танилцуулж, үүнийг улам баяжуулж хэрэгжүүлэх талаар арга зүйн зөвлөмж өглөө.

Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ оалбан тушаалд анх орох иргэдээс төрийн албаны мэргэшлийн шалгалтыг тайлант онд 1 удаа, Төрийн албаны удирдах албан тушаалтанд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг тайлант онд 2 удаа зохион байгуулсан ба нэр дэвшүүлэх тогтоол гаргуулж томилох эрх бүхий этгээдэд уламжласны зэрэгцээ ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх дарга /захирал, эрхлэгч/-ийн сонгон шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулж явуулсан ба эдгээр сонгон шалгаруулалтын үр дүнгээр нэр дэвшүүлсэн иргэд нь тухайн албан тушаалтанд томилогдон ажиллаж энэ талаар маргаан гараагүй болно.

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон төрийн жинхэнэ албаны удирдах ажилтанд томилогдох ажилтанг нөөцөд бүртгэх нөөцийн сан бүрдүүлэх, нөөцийн сангийн мэдээллээр үйлчлэх ажлыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэж, мэдээг тухай бүр хүргүүлж байв. Жилийн эцсийн нөөцийн судалгааны тайланг жилийн ажлын тайлантай хамт хүргүүллээ.

Төрийн захиргааны жинхэнэ удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын удирдах ур чадвар, манлайллыг дээшлүүлэхг гүйцэтгэх ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулж, ажлыг бодитой үнэлэхэд төсвийн ерөнхий захирагч, ерөнхий менежер, төрийн албан хаагчидтай байгуулах үр дүнгийн гэрээний шалгуур үзүүлэлтийг бодитой болгох, түүнийг бодитой дүгнэх, энэ талаар гарсан заавар журмыг ягштал биелүүлэх, биелэлтэнд хяналт тавих зэрэг ажлыг салбар зөвлөлөөс өдөр тутам удирдлагаар хангаж арга зүйн зөвлөлгөө өгч ажиллаа.

Салбар зөвлөлийн нэг үндсэн ажил болох харьяатын дагуу төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшигчдын хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг УИХ-аас баталсан

журмын дагуу шийдвэрлэж байв. Энэ талаар тайлангийн дээрх бүлэгт тодорхой тусгасан юм.

Төрийн жинхэнэ албан хаагчийг бэлтгэх, мэргэшүүлэх мэргэшлийг дээшлүүлэх давтан сургах сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх биелэлтэнд хяналт тавих, энэ ажлыг удирдан зохион байгуулахад арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллаа. Энэ талаар хийсэн ажлыг тайланд дэлгэрэнгүй тусгав.

Төрийн албан хаагчид холбогдолтой мэдээ судалгаа, тайланг аймгийн харьяа байгууллагуудаас гаргуулан нэгтгэх дээд байгууллагаас шаардсан мэдээ судалгааг цаг хугацаанд тасалдуулахгүй хүргүүлэн ажилласан болно.

Эдгээр ажлын үр дүнд салбар зөвлөлийн дотоод ажилд ахиц дэвшил гарч урьд шалган зааварлах ажлын явцад гарсан гол зөрчил дутагдал арилж эдгээр зөрчил дутагдал давтан гарах нөхцөл боломж бүрэн хаагдаж, салбар зөвлөлийн ажил жигдэрсэн гэж үзэж байна.

Салбар зөвлөлийн уйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл шийдвэрлэвэл зохих асуудал тэдгээрийг шийдвэрлэх арга зам

Салбар зөвлөл нь улс төрийн үзэл бодлоос хараат бус байж, аливаа асуудлыг гишүүдийн хуралдаанаар хэлэлцэж, хамтын удирдлагын шийдвэр гаргадаг, зөвхөн төрийн албаны тухай хууль, тогтоомж, стандартанд захирагдах ёстой. Энэхүү зарчимд тулгуурлан гаргах салбар зөвлөлийн шийдвэрт улс төрийн шахалт дарамт үзүүлэх, гаргасан шийдвэрийг мушгин гуйвуулж улс төржүүлэх оролдлого хийх, шийдвэрийг биелүүлэхээс татгалзах, хууль тогтоомж, стандартыг зөрчих явдал гаргахгүй байх талаар анхааран ажиллаж байна.

Төрийн албаны тухай хууль, тогтоомж стандартыг зөрчсөн улс төрийн албан тушаалтанд хариуцлага тооцох, гарсан зөрчил дутагдлыг таслан зогсоох эрх хэмжээ салбар зөвлөлд төдийлөн байхгүй, зөвхөн шүүхээр маргааныг шийдвэрлүүлж байна.

Нөгөө талаар сум, нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага, тухай бүр гарсан төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны захиалгыг өгөхгүй байх, өгсөн нөхцөлд өөрийн талын иргэнд зориулан ажлын байрны тодорхойлолт ирүүлдэг, тэр бүрийг салбар зөвлөл өөрчлөх

боломжгүй, зарлах ч боломжгүй болдог, дахин буцаадаг, цаг хугацаа алддаг, энэ хооронд өөрсдийн хүмүүсийг томилдог зэрэг нийтлэг дутагдал байна.

Иймд орон нутгийн төрийн захиргааны удирдах ажилтнуудын ажлын байрны {албан тушаал}-ын тавигдах ерөнхий болон тусгай шаардлагын жишгийг хуулийн дагуу боловсруулж мөрдөх.

ХНУМСП-ыг боловсронгуй болгох жил бүр уг программд тусгах, нийт төрийн албан хаагчдын цалингийн мэдээллийг Сангийн яам буюу орон нутаг дахь төрийн санд шилжүүлэх.

Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг орон тооны болгож, цалингийн ангилал зэрэглэлийг нэмэгдүүлэх.

Салбар зөвлөлийн гишүүдэд, хуралд оролцсон, маргаан хянан шалгах комисст ажилласан , шалган зааварлах ажилд оролцсон зэрэг ажлыг бодитой дүгнэж, жилд 2-оос доошгүй удаа шагнал урамшуулал олгох, хариуцлага тооцох журам боловсруулж мөрдөх зэрэг саналуудыг хүргүүлж байна.

Салбар зөвлөлийн жилийн ажлын тайланд танилцаж үнэлгээ дүгнэлт өгч, цаашид ажилд чиглэл өгнө гэдэгт итгэж байна.

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛ**